

## ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМЫН ДҮРЭМ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗААВАР

### Нэг. Нэр томъёоны тодорхойлолт

- 1.1. “Гишүүн” гэж Иргэдийн Оролцооны Нэгдэл Намын дүрэм (цаашид “Намын дүрэм” гэх)-ийн 5 дугаар зүйлд дурдсаныг бүхэлд нь ойлгоно.
- 1.2. “Ажиглагч гишүүн” гэж Намын дүрмийн 5.4 ба 5.5-д заасныг ойлгох ба ажиглагч гишүүн нь гишүүний жилийн татвараа төлөөгүйгээс тухайн жилийн хурал, дотоод сонгуульд санал таслах эрх нь түдгэлзсэн иргэн байна.
- 1.3. “Татвар төлөгч гишүүн” гэж Намын дүрмийн 5.6, 5.7 ба 5.10-т заасныг тус тус ойлгох ба татвар төлөгч гишүүн нь Төлөөлөгчдийн Танхимаас тогтоосон гишүүний жилийн татварыг дүрмийн 22.1 дэх заалтаар тогтоосон хугацаанд буюу жил бүрийн 2 дугаар сарын 1-ний дотор тогтоосон дансанд төлсөн, эсхүл намын хандивлагч гишүүн болох нь санхүүгийн бүртгэлээр баталгаажсан, тухайн жилийн аливаа хурал, дотоод сонгуульд санал таслах эрхтэй иргэн байна.
- 1.4. “Хандивлагч гишүүн” гэж Намын дүрмийн 5.8 ба 5.9-д заасныг ойлгох ба сум, хорооны салбар, аймаг, дүүрэг, нийслэлийн танхимын жилийн зардлын 20-оос дээшгүй хувийг намын дүрмийн 22.3-т заасан тоо хэмжээгээр санхүүжүүлж буй гишүүн байна.
- 1.5. “Хуримтлал бүрдүүлэгч гишүүн” гэж Намын дүрмийн 5.11-т заасныг ойлгоно. Хуримтлал бүрдүүлэгч гишүүн нь улс төрийн сонгуульд нэр дэвших сонирхлоо илэрхийлэн улс төрийн хуримтлал бүрдүүлэх ориулалттай нэрийн хуримтлалын дансаа намын Бүртгэгчид бүртгүүлж, намын дүрмийн 22.1 дэх заалтаар тогтоосон хугацаанд өмнөх жилийн хуримтлалынхаа 1 хувиас хэтрэхгүй хэмжээтэй татварыг төлсөн, төрийн сонгуульд нэр дэвшүүлэх намын дотоод сонгууль, шалгаруулалтад нэр дэвших эрхтэй иргэн байна.
- 1.6. “Намын сонгуульд албан тушаал” гэж Намын дарга, салбар, танхимын дарга нар, намын ерөнхий менежер, намын бүртгэгч болон Төлөөлөгчдийн танхимын гишүүн, Маргаан таслах комиссын гишүүн, Үнэт зүйлийн зөвлөлийн гишүүн, Нийслэл, аймаг, дүүрэг, сум, хорооны Танхимын гишүүнийг тус тус ойлгоно.
- 1.7. “Улс төрийн албан тушаал” гэж Төрийн албаны тухай хуульд заасан төрийн улс төрийн албан тушаал хэмээх тодорхойлолтонд заасан албан тушаалыг ойлгоно.
- 1.8. “Хурал” гэж намын сонгуульд гишүүд буюу эсвэл татвар төлөгч гишүүдэд дүрмийн дагуу зарлагдсан, тэдгээр гишүүд санал таслах эрхтэй оролцож санал таслах үйл ажиллагаа явагдсан аливаа танхимын болон цахим, эсвэл хосолсон цуглааныг ойлгоно. Энэ заалтад “санал” гэж намын дүрмэнд тухайн хурлын бүрэн эрхийн хүрээнд томъёолж гишүүдээр шийдүүлэхээр эрх бүхий субьектээс оруулсан сонголт хийх хувилбарыг

хэлнэ.

## **Хоёр. Намын нэгдсэн цахим систем, түүнд агуулагдах мэдээлэл, ашиглах горим**

### **2.1. Намын веб сайт.**

- 2.1.1. Намын албан ёсны веб хуудас нь Намын дүрмийн 1.3.5-д заасны дагуу [www.cup.mn](http://www.cup.mn) хаяг байх бөгөөд энэхүү веб хуудаст дараах мэдээлэл заавал орно.
- 2.1.2. Мэдээ мэдээлэл. Энэ хэсэгт нийтийн зар, бусад зар болон олон нийттэй харилцах мэдээллийг байршуулна.
- 2.1.3. Намын гишүүдийн тоо, хүйсийн болон орон нутгийн задаргаа.
- 2.1.4. Намын шилэн данс. Үүнд намын үндсэн дансны дугаар, орлого, зарлага, үлдэгдлийн хэмжээ, татвар болон хандив төлсөн хүний тоо байнга нийтлэгдэх ба намын санхүүгийн жилийн нэгдсэн тайлан, сонгуулийн санхүүгийн тайлан, намын санхүүд хийсэн аудитын дүгнэлт, намын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, мөрдөгдөх стандартыг тус тус нийтлэнэ.
- 2.1.5. Намын дарга, Төлөөлөгчдийн танхим, Үнэт зүйлийн зөвлөл, Маргаан таслах комиссын гишүүдийн танилцуулга.
- 2.1.6. Намын дүрэм, журам, мөрийн хөтөлбөр, тушаал, шийдвэр, дүгнэлт, зөвлөмж зэрэг батлагдсан баримт бичиг, хэлэлцүүлгийн шатны төслийн файлын сан унших, сонсох, үзэх хувилбараар.
- 2.1.7. Намын хаяг. Үүнд намын төв болон салбар ажлын алба байрлаж буй хаяг, электрон шуудан, холбогдох ажлын албыг удирдаж буй албан тушаалтны нэр.
- 2.1.8. Намд гишүүнээр элсэх аппликейшн татан авах холбоос.
- 2.1.9. Намын тухай олон нийтийн дунд түгж буй мэдээ мэдээллийг татан авч түгээх холбоос.
- 2.1.10. Төрийн болон намын дотоод сонгуульд нэр дэвшигчдийг танилцуулах хэсэг, үүнд гишүүдийн танилцуулга, албан ёсны хаяг, хандивын дансны мэдээлэл.
- 2.1.11. Намын дүрмийн 18 дугаар зүйлд заасан намын үйл ажиллагааны онооны системд бүртгүүлэх, холбогдох холбоос
- 2.1.12. Намын дотоод удирдлагын нэгдсэн самбарт (dashboard)-д холбогдох хэсэг.
- 2.1.13. Намын веб сайтад нэвтрэх эрх бүхий админыг Бүртгэгч бүртгэж, өөрчлөлт нэг бүрийг шинэчилнэ.

### **2.2. Намын үйл ажиллагааны онооны систем.**

- 2.2.1. Намын үйл ажиллагааны онооны системийг намын ажлын албад хариуцан хөтөлнө. Намын үйл ажиллагааны онооны систем нь намын гишүүдэд нээлттэй байх бөгөөд дараахь мэдээллийг агуулсан байна.
- 2.2.2. Гишүүдийн тоо, аймаг, дүүрэг, сум, хот, хорооны харьяаллаар;
- 2.2.3. Татвар төлөгч гишүүдийн тоо, аймаг, дүүрэг, сум, хороо бүрээр;
- 2.2.4. Хандивлагч гишүүдийн тоо, хандивын орлогын хуваарилалт намын байгууллагын данс бүрээр;
- 2.2.5. Хуримтлал бүрдүүлэгч гишүүний тоо аймаг, дүүрэг, сум хороо бүрээр.
- 2.2.6. Хуримтлалын татварын хэмжээ хуримтлал бүрдүүлэгч гишүүн бүрээр.
- 2.2.7. Хуримтлал бүрдүүлэгч гишүүний олон нийтээд танигдалт, улс төр нийгмийн ажлын үнэлгээний тоон үзүүлэлт, орон нутгаар ба үндэсний хэмжээнд.
- 2.2.8. Хуримтлал бүрдүүлэгч гишүүн тухайн жилийн/улиралын/гэнэтийн тандалт үнэлгээнд орохыг хүссэн хүсэлт илгээх, тест бөглөх холбоос. Үүнд, хуримтлал бүрдүүлэгч гишүүн тухайн сонгуулийн жилийн тандалт үнэлгээнд орохын өмнө Намын дүрэм болон Улс төрийн намын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн

талаар тест бөглөн 85-с дээш хувийн амжилт үзүүлсний дараа хүсэлтийг систем хүлээн авна. Тестийг нэг гишүүн хэдэн ч удаа өгч болох бөгөөд 3 хоног тутамд нэг удаа тест бөглөх эртэй байхаар зохицуулна.

- 2.2.9. Намын гишүүн тухайн тандалт, үнэлгээнд өрсөлдөж буй хуримтлал бүрдүүлэгч гишүүдийн талаар санал өгөх, үнэлгээ дүгнэлт бичих холбоос;
- 2.2.10. Намын гишүүний байнгын оноо бүрдүүлэх хэсэг. Үүнд, тухайн гишүүний намын үйл ажиллагаанд оролцсон оролцоо, хурлын ирц, тухайн гишүүний талаар Үнэт зүйлийн зөвлөлийн дүгнэлт, Маргаан таслах комиссын зөвлөмж, Дотоод аудитын хорооны дүгнэлт, намын дотоод болон төрийн сонгуульд авсан санал зэрэг нэмэлт мэдээллийг намын ажлын албанаас оруулах цэс.
- 2.2.11. Намын онооны системд нэвтрэх эрх бүхий админуудыг Бүртгэгч бүртгэж, өөрчлөлт нэг бүрийг шинэчилнэ.

### **2.3. “Иргэний оролцоо” аппликейшн**

- 2.3.1. “Иргэний оролцоо” аппликейшн (цаашид “намын апп” гэх) нь намын гишүүнийг бүртгэх, намын гишүүнд нийтийн зар, мэдээллийг тэгш хүргэх, намын гишүүн цахимаар санал хураалтад оролцох, хэрэгсэл мөн. Намын апп дараах горимоор ажиллана.
- 2.3.2. Play Store ба AppStore дээр байх “Иргэний оролцоо” аппликейшнийг намд элсэхийг хүссэн иргэн татаж аван, холбогдох зааврын дагуу өөрийгөө бүртгүүлснийг дотоод удирдлагын нэгдсэн самбарт админ эрхтэй этгээд баталгаажуулснаар дахин давтагдашгүй код бүхий и-батлах үүсч тухайн гишүүн намд элссэнд тооцогдоно.
- 2.3.3. Хэрэв бүртгүүлсэн иргэн нь насанд хүрээгүй, гадаад орны иргэншилтэй бол энэ мэдээллийг Бүртгэгчид уламжилна. Бүртгэгч мэдээллийг нягтлаад Монгол улсын хуульд үл нийцэх нь батлагдвал ажлын 5 хоногийн дотор уг иргэний бүртгэлийг “идэвхигүй” горимд оруулна.
- 2.3.4. Намын апп-ын мэдээллийн сан нь Намын дотоод удирдлагын нэгдсэн самбарт (dashboard)-д хуримтлагдах бөгөөд тус нэгдсэн самбарт нэвтрэх эрх бүхий админуудыг Бүртгэгч бүртгэж, өөрчлөлт нэг бүрийг шинэчилнэ.

### **2.4. Нээлттэй цахим системийг намын үйл ажиллагаанд ашиглах**

- 2.4.1. Нам нь нийгмийн сүлжээнд (Facebook, Twitter, Instagramm, Linkedin гэх мэт) өөрийн баталгаажсан (verified) хаягтай байх бөгөөд хаяг дээр цахим хуудас дээр гарч буй шинэ мэдээллийг түгээж байна.
- 2.4.2. Намын нийгмийн сүлжээн дэх хаягийг ажлын албадын ажилтнууд хөтөлнө. Нийгмийн сүлжээн дэх намын хаягт нэвтрэх эрх бүхий админуудыг Бүртгэгч бүртгэж, өөрчлөлт нэг бүрийг шинэчилнэ.

### **2.5. Намын ажлын алба цахим орчинд ажиллах, утсан холбоо харилцаа**

- 2.5.1. Намын вебсайт, нийгмийн сүлжээ, онооны системд админаар бүртгэгдсэн ажилтангууд цахим халдлагаас сэргийлэх сургалтанд суух ба хичээлийн агуулгын дагуу Намын цахим хаягуудыг хамгаалах арга хэмжээг авна.
- 2.5.2. Намын Ажлын алба дотооддоо үүлэн тооцоолуур (cloud computing service) дээр суурилсан Microsoft Teams эсвэл Google+ гэх мэт программ хангамжийг ашиглана. Цахим уулзалт, хурал, сургалтын үйл ажиллагаанд Zoom системийг ашиглах ба уг систем нь нэг зэрэг олон админ бүртгүүлэх болох хурал зохион байгуулах боломжтой

байна. Оффисын болон цахим хурлын бүх программ хангамж албан ёсны эрхтэй буюу licensed байна.

- 2.5.3. Намын аливаа бичиг баримтын боловсруулалт онлайн платформ дээр, гишүүдийн олон талын оролцоотойгоор shared байдлаар хийгдэх бөгөөд энэхүү платформ дээр ажиллах нөхцлийг хангаж өгөх үүргийг Ажлын Алба хүлээнэ.
- 2.5.4. Нам албан ёсны бүх утсан харилцаа нэг сувгаар хийгдэх ба 7xxx xxxx тусгай дугаарт Намын Ажлын Албаны бүх нарийн бичгийн дарга нарын гар утас холбогдсон байна. Хэрэв Ажлын Албаны ажилтнууд хувийн дугаараа албаны зориулалтаар ашиглахгүй гэсэн тохиолдолд Намын зүгээс давхар дугаар олгох, ашиглахтай холбоотой зардлыг хариуцна. Гишүүдийн чөлөөтэй харилцах боломжийг хангах үүднээс тусгай дугаарыг олон оператороос авсан бол сүүлийн 4 орон ижил байна.

## **Гурав. Намын татвар, хандив төлөх, гишүүний төлөвийг бүртгэх, өөрчлөлт оруулах**

### **3.1. Татвар, хандив төлөх**

- 3.1.1. Намын гишүүн жилийн татвараа жил бүрийн 1 дүгээр сарын 1-нээс эхлэн төлж болох ба 2-р сарын 1-ний 00 цагаас өмнө намын үндсэн дансанд Төлөөлөгчдийн Танхимын тогтоосон хэмжээгээр төлсөн байна. Гишүүний татвар төлөх гүйлгээний утга нь тухайн гишүүний и-батлах дээр буй 8 оронтой бүртгэлийн дугаар байна.
- 3.1.2. Хуримтлал бүрдүүлэгч гишүүний татвар төлөх гишүүн жил бүрийн 1 сарын 1-ний 00 цагаас 2 сарын 1-ний 00 цагийн хооронд өөрийн нэрийн улс төрийн хуримтлалын данснаас намын үндсэн дансанд өөрийн тогтоосон хэмжээний татварыг төлнө. Ингэхдээ өмнөх жилийн хуримтлалын 1 хувиас хэтрэхгүй хэмжээний татварыг төлж гүйлгээний утга хэсэгт иргэний бүртгэлийн регистрийн дугаар, намын и-батлахын 8 оронтой дугаар, “хуримтлал” гэдэг үгийг тус тус бичнэ.
- 3.1.3. Хандивлагч гишүүн, эсхүл намын гишүүн бус иргэн, хуулиар зөвшөөрсөн бусад этгээд намын үндсэн дансанд болон намын нийслэл, аймаг, дүүрэг, сум, хорооны салбарын дансанд хандив өгч болно. Хандивлагч гишүүний хувьд намын гишүүн хандив өгөхдөө гүйлгээний утга хэсэгт иргэний бүртгэлийн регистрийн дугаар, и-батлахын 8 оронтой дугаар, “хандив” гэдэг үгийг тус тус бичнэ. Харин намын гишүүн бус Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага намын дэмжигчийн хувьд хандив өгөхдөө гүйлгээний утга хэсэгт иргэн, хуулийн этгээдийн регистрийн дугаар, “хандив” гэдэг үгийг бичнэ .
- 3.1.4. Монгол улсын хууль, намын дүрмээр хориглосон этгээдээс, эсвэл зөвшөөрснөөс илүү хэмжээгээр намын дансанд хандив орсон бол уг хандивыг намын санхүүч буцаан шилжүүлнэ.
- 3.1.5. Нэг данснаас, эсхүл нэг мөнгө тушаагч 2 буюу түүнээс дээш гишүүний татварыг төлсөн тохиолдолд уг орлогын талаархи мэдээллийг намын санхүүч Эрсдлийн Удирдлагын нэгжид хянуулахаар хүргүүлэх бөгөөд, Эрсдлийн Удирдлагын нэгж тус маргаантай татвар төлөлт хийсэн гишүүнээс тайлбар авч илүү төлөлтийг буцаах, эсхүл бүртгэлд болон бусдын саналын эрхийг өөрчлөхийг оролдсон гишүүний үйл ажиллагааны онооны системийн байнгын оноо бүрдүүлэх хэсэгт энэ тухай анхааруулга, мэдээллийг Ажлын алба оруулна.

### **3.2. Гишүүний төлөвийг бүртгэх, өөрчлөлт оруулах**

- 3.2.1. Санхүүгийн алба тухайн жил татвар төлсөн гишүүдийн жагсаалтыг Бүртгэгчид илгээх

ба Бүртгэгч тухайн жилийн татвар төлсөн болон төлөөгүй гишүүдийн гишүүнчлэлийн төлөвт орж буй өөрчлөлтийг цахим санд оруулах хүсэлтийг Мэдээллийн технологи хариуцсан ажилтанд өгнө. Татвараас хамааран төлөвт нь өөрчлөлт орсон гишүүдийн мэдээллийг Ажлын албаны мэдээллийн технологи хариуцсан ажилтан намын апп-д оруулна.

- 3.2.2. Намын жилийн татварыг хугацаанд нь төлөөгүй хэрнээ намын дүрмийн 5.10-т заасны дагуу намын татвараас илүү хэмжээгээр хандив төлсөн хандивлагч гишүүнийг татвар төлөгч гишүүн-хандивлагч төлөвөөр давхар бүртгэнэ. Хандивын хэмжээ жилийн татварын хэмжээтэй тэнцүү буюу бага бол хандивлагч гишүүнээр бүртгэнэ. Татвар төлөгч гишүүний тоо 1 дүгээр сарын 31-нээс хойш ийн нэмэгдсэн тухай мэдээллийг намын санхүүч Бүртгэгчид тухай бүр и-мейлээр мэдээлнэ. Бүртгэгч нь эдгээр гишүүний төлөвийн тухай мэдээллийг нэгтэн 4 дүгээр сарын 1-нээс 12 дугаар сарын 1-ний хооронд сар бүрийн эхний 5 хоногт багтаан намын цахим системд оруулна.
- 3.2.3. Жил бүрийн 2 дугаар сарын 15-нд татвар төлөгч гишүүдийн тоог намын веб сайтаар зарласнаас хойш хоёр сарын хугацаанд намын гишүүдийн төлөвт нэмэлт, өөрчлөлт оруулахгүй. Энэ журмын 3.1.5-д заасны дагуу гишүүний төлөв өөрчлөгдсөн гишүүн нь намын дотоод сонгуулиас бусад, тухайн жилд зохиогдох хурал, хэлэлцүүлэг, санал асуулгад оролцож санал таслах эрхээ эдэлнэ.

## **Дөрөв. Намын дотоод сонгууль зохион байгуулах**

### **4.1. Дотоод сонгууль ба зохион байгуулах эрх бүхий байгууллага**

- 4.1.1. Намын дүрмийн 9.2.2, 9.2.4, 9.3, 9.5, 9.6.1, 9.6.2, 9.6.3, 9.6.7, 9.6.11, 10.2.1, 10.2.2, 10.2.3, 10.4.3, **11.2**, 11.8.2, 11.9.1, 11.9.2, 12.2-д тус тус заасан сонгуулийг эрх бүхий намын бүтцийн байгууллага зохион байгуулахыг намын дотоод сонгууль гэж үзнэ.
- 4.1.2. Дотоод сонгууль нь ээлжит ба нөхөн сонгууль хэлбэртэй байна.
- 4.1.3. Намын дотоод сонгуулийн санал хураалт цахимаар, блокчейн технологид суурилан явагдана. Зөвхөн цахим технологи ашиглах боломжгүй нөхцөл байдалд цаасан саналын хуудсыг ашиглаж болно.
- 4.1.4. Намын дүрмийн 11.2-т заасан сонгуулийг Намын дотоод сонгуулийн төв ажлын хэсэг удирдан сум, хорооны дотоод сонгуулийн ажлын хэсгийг оролцуулж зохион байгуулна.
- 4.1.5. Намын дүрмийн 9.2.2, 9.2.4, 9.3-т заасан сонгуулийн санал хураалтыг Намын Их Хурал, 9.3, 9.5, 9.6.1, 9.6.2, 9.6.3, 9.6.7, 9.6.11, 12.2-т заасан сонгуулийн санал хураалтыг Төлөөлөгчдийн Танхим, 11.8.2-т заасан сонгуулийн санал хураалтыг Нийслэлийн Танхим, 11.9.1-т заасан сонгуулийн санал хураалтыг аймаг, дүүргийн танхим, 11.9.2-т заасан сонгуулийн санал хураалтыг нийслэл, аймаг, дүүргийн танхимын хурлаар тус тус зохион байгуулах бөгөөд эдгээр сонгуульд нэр дэвшигчийг бүртгэх, сонгуулийн саналын хуудас батлах, нэр дэвшигчдийн өрсөлдөөнд тэгш оролцох нөхцлийг хангах үүргийг Намын дотоод сонгуулийн төв ажлын хэсэг хүлээнэ.
- 4.1.6. Намын дүрмийн 10.2.1, 10.2.2, 10.2.3-т заасан сонгуулийг сум, хорооны бүх гишүүдийн хурал, 10.4.3-т заасан сонгуулийг сум, хорооны танхим явуулах бөгөөд уг сонгуульд нэр дэвшигчийг бүртгэх, сонгуулийн саналын хуудас батлах, нэр дэвшигчдийг өрсөлдөөнд тэгш оролцох нөхцлийг хангах үүргийг сум, хорооны дотоод сонгуулийн ажлын хэсэг хүлээнэ.

### **4.2. Намын дотоод сонгуулийн хугацаа**

- 4.2.1. Намын дүрмийн 16.2-т заасны дагуу намын бүх дотоод сонгуулийг жил бүрийн 3 дугаар сарын 1-нээс 3 дугаар сарын 31-ний хооронд багтаан зохион байгуулна. Тухайн жил болох дотоод сонгуулийн товыг Төлөөлөгчдийн танхим өмнөх оны 12 дугаар сарын 1-нээс 12

дугаар сарын 31-ний хооронд тогтоож намын веб сайтын “нийтийн зар” хэсэгт товыг нийтэлнэ. Нөхөн сонгуулийг Төлөөлөгчдийн танхим шаардлагатай гэж үзвэл тусад нь зарлаж болно.

4.2.2. Дотоод сонгуулийн төв ажлын хэсгийг Төлөөлөгчдийн Танхим жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор байгуулж ажлын хэсгийг даргыг нийтэд зарлана.

4.2.3. Дотоод сонгуулийн сум, хорооны ажлын хэсгийг тухайн сум, хорооны танхим 1 дүгээр сарын 25-ны дотор байгуулж ажлын хэсгийн дарга, гишүүдийн жагсаалтыг Дотоод сонгуулийн төв ажлын хэсгийн даргад ирүүлнэ.

4.2.4. Дотоод сонгуулийн төв болон сум, хорооны ажлын хэсэг тухайн жилд явагдах дотоод сонгуулийн бэлтгэл ажил, нэр дэвшигчийн бүртгэлийг 2 дугаар сард багтаан зохион байгуулна.

4.2.5. Намын дүрмийн 9.6.7, 10.2.3, 11.9.2-т заасан сонгуулийг зохион байгуулах хуулийн хугацаа нь намын дүрмийн 16.2-т заасан хугацаатай нийцэж байвал намын дүрэмд заасан хугацаанд эдгээр сонгуулийг зохион байгуулна. Харин хуулийн хугацаа, дүрмээр заасан хугацаатай нийцэхгүй байвал хуулийн хугацаанд нийцүүлж зохион байгуулна.

4.2.5. Намын дүрмийн 9.6.7, 10.2.3, 11.9.2-т заасан сонгуулийг зохион байгуулах хуулийн хугацаа дүрмийн 16.2-т заасан хугацаатай нийцэхгүй тохиолдолд эдгээр сонгуулийг зохион байгуулах дотоод сонгуулийн ажлын хэсгийг тусад нь, тухайн сонгууль явагдахаас 2 сарын өмнө байгуулна.

4.2.6. Гураваас дээш орон гарсан суудалд нөхөн сонгууль зарласан, нөхөн сонгууль товлогдсон огноо нь намын дүрмийн 16.2-т заасан дотоод сонгуулийн эхлэх буюу дуусах хугацааны аль нэгээс гурван сараас илүү хугацаанд таарч байгаа бол дотоод сонгуулийн ажлын хэсгийг тус нөхөн сонгууль болохоос хоёр сарын өмнө байгуулна. Гурав ба түүнээс цөөн орон тоонд нөхөн сонгуулийг мөн хугацаанд зарласан бол тухайн сонгууль зарласан бүтцийн байгууллагын хуралд бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг буюу ажлын алба сонгуулийг бүрэн хариуцан зохион байгуулна.

4.2.7. Намын дүрмийн 16.2-т заасан хугацааны эхнээс 3 сарын өмнө, мөн хугацаа дууссанаас хойш 3 сарын дараах өдөр хүртэлх хугацаанд нөхөн сонгууль товлон зарлахгүй.

### **4.3. Намын дотоод сонгуулийн тов, үйл ажиллагаа**

4.3.1. Энэ журмын 4.2.1-д заасан товын талаар шийдвэр гаргахын өмнө Төлөөлөгчдийн Танхимын гишүүдэд дараах мэдээллийг Ажлын Албанаас бэлтгэж хүргэсэн байна:

4.3.1.1. Намын сонгуульд албан тушаалд орон гарсан эсэх;

4.3.1.2. Ээлжит төрийн сонгуулийн жилтэй холбогдуулан аймаг, дүүрэг, нийслэлийн танхим, сум, хорооны бүх гишүүдийн хурлаар зарим дотоод сонгуулийг бүхлээр нь буюу хэсэгчлэн нэг жил хүртэлх хугацаагаар хойшлуулах санал гаргаж дэмжигдсэн эсэх;

4.3.2. Намын дотоод сонгууль зарлах эрх бүхий байгууллага энэ журмын 4.3.1-д заасан нөхцөл байдлыг үнэлж дотоод сонгуулийг орон гарсан суудалд зарлана.

4.3.3. Дотоод сонгуулийн товд сонгууль зарлагдаж буй албан тушаал, орон гарсан тоо, сонгуулийн санал авах огноо, санал хураалтыг эхлэх, хаах цагийг тус тус заавал оруулна. Сонгууль зарлагдаж буй албан тушаалд жендер, орон нутаг, нийгмийн бүлгийн суудал байгаа бол энэ тухай товд тусгана.

4.3.4. Дотоод сонгуулийн товын дагуу Дотоод сонгуулийн ажлын хэсэг дараах үйл ажиллагааг зохион байгуулна.

4.3.4.1. Нэр дэвшигчийн бүртгэлийг нээх, хаах, сурталчилгаа эхлэх, дуусах, нэрээ татах эцсийн хугацааг тус тус зарлах. Нэр татах сүүлийн хугацаа нь санал авах өдрөөс 7 хоногийн өмнө байна.

4.3.4.2. Нэр дэвшигчийн бүрдүүлэх материалын жагсаалтыг намын дүрмийн дагуу гаргаж, нэр дэвшигчийн бүртгэлийг зохион байгуулах. Ингэхдээ нэр дэвшигчид цахимаар хүсэлтээ гаргах нөхцлийг хангана. Нэр дэвшигчийн сурталчилгааны зардлыг бууруулах, харилцааны тэгш, шуурхай байдлыг хангах зорилгоор нэр дэвшигчийн бүрдүүлэх материалд товч намтар (онлайн анкет), зураг, цахим хаяг (и-мейл, фейсбүүк, твиттер, инстаграм)-ийн мэдээллийг заавал оруулна.

4.3.4.3. Намын дүрмийн 9.6.7, 10.2.3, 11.9.2-т заасан дотоод сонгуулийн нэр дэвшигчдийг бүртгэхдээ намын үйл ажиллагааны онооны систем ашиглах

4.3.4.4. Нэр дэвшигчдэд сурталчилгааны үеэр хориглох үйлдлийг сануулах, үнэмлэх олгох, нэр дэвшигчдийн саналын хуудас дах дарааллыг үүсгэх.

4.3.4.5. Сонгуулийн саналын хуудас бэлтгэж, саналын хуудсыг сонгуулийн санал хураалт эхлэхээс 5 хоногийн өмнө цахим санал хураалтын системд оруулж, санал таслах эрхтэй гишүүдэд нийтлэг болон тусгай зарын аргаар мэдэгдэл хүргүүлэх.;

4.3.4.6. Санал таслах эрхтэй гишүүд дотоод сонгуульд хэрхэн оролцох талаар мэдээлэл бэлтгэж намын веб сайтад болон сошл хаягуудад нийтлүүлэх.

4.3.4.7. Нэр дэвшигчдэд сурталчилгааны тэгш талбар бүрдүүлэх. Хөгжлийн бэрхшээлийг тооцож сурталчилгааг хүртээмжтэй аргаар зохион байгуулах ба сонсголын бэрхшээлтэй нэр дэвшигчдэд дохионы хэлний орчуулгатайгаар харилцах цагийг нэмж тооцож олгоно.

4.3.4.8. Төлбөртэй сурталчилгааг дотоод сонгуулийн ажлын хэсэг зохион байгуулж болохгүй. Төлбөртэй сурталчилгаа үйлчилгээний боломж байгаа тухай зарыг дотоод сонгуулийн ажлын хэсэг нэр дэвшигчдэд тэгш хүргэж болно.

4.3.4.9. Санал хураалт зохион байгуулах, урьдчилсан санал хураалтыг санал хураалтын өдрөөс 72 хүртэлх цагийн өмнө эхлүүлэх, санал хураалт зохион байгуулахад эрх бүхий хурлын дарга, тооллогын комисст туслах.

4.3.5. Дотоод сонгуульд өрсөлдөх нэр дэвшигч нь тухайн сонгуульд тусгайлан тавигдах шаардлагаас гадна дараах үүрэг, эрхтэй байна:

4.3.5.1. Иргэдийн оролцооны намын гишүүн сум, хорооны шатанд 2, аймаг, дүүргийн шатанд 10, нийслэл, улсын шатанд 50 намын гишүүнээс бичгээр дэмжлэг авсны дараа дотоод сонгуульд нэрээ дэвшүүлнэ. Нэр дэвшигчийг дэмжиж буй баримтад гишүүн намын и-батлахын бүртгэлийн 8 оронтой дугаарыг тэмдэглэх бөгөөд нэг сонгуульд хоёр буюу түүнээс дээш нэр дэвшигчийг дэмжсэн саналын и-батлахын бүртгэлийн дугаар давхардаж болохгүй.

4.3.5.2. Гишүүн нь дотоод сонгуульд нэр дэвшигчдийн бүрдүүлэх материалыг үнэн зөв, бүрэн бүрдүүлэх үүрэгтэй.

4.3.5.3. Намын гишүүн намын үйл ажиллагааны онооны системд хамрагдаж, өөрийн оноог сурталчилгаанд ашиглах эрхтэй.

4.3.5.4. Хуримтлал бүрдүүлэгч гишүүн нэр дэвшсэн бол бүрдүүлсэн хуримтлалаасаа сурталчилгааны зардал гаргах эрхтэй.

#### **4.4. Дотоод сонгуулийн дүн гаргах, маргаан шийдвэрлэх**

4.4.1. Дотоод сонгуулийн санал хураалтын дүнг тус сонгуулийн санал хураалтыг зохион байгуулах эрх бүхий намын бүтцийн байгууллагын болон ажлын хэсгийн хурлын тогтоолоор баталж хурлын дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.

4.4.2. Дотоод сонгуулийн санал хураалтын дүн тогтоолоор баталгаажмагц дүнг баталсан тогтоолд гарын үсэг зурсан хурлын дарга олон нийтэд зарлана.

4.4.3. Дотоод сонгуулийн санал хураалтын дүн намын нэгдсэн цахим системд хадгалагдана.

### **Тав. Намын ээлжит хурлын нэгдсэн календарь, хэлэлцэх асуудал**

5.2. Намын дүрэмд заасан хурал, хэлэлцэх асуудал, хэлэлцэх хугацааг баримталж зохион байгуулсан бүх хурал нь ээлжит хуралд тооцогдоно.

5.3. Намын ээлжит хурлуудын нэгдсэн календарь нь дор дурдсанаар байх бөгөөд уг хурлууд болон дотоод сонгуулийг товлон зарлах эрх бүхий этгээд товыг нарийвчлан тогтоохдоо доорх нэгдсэн хуваарьт захирагдаж намын үйл ажиллагааны уялдаа холбоо, тасралтгүй байдлыг хангана.

Хугацаа		Ээлжит хурал хийх намын бүтцийн байгууллага	Заавал хэлэлцэх асуудал
сар	өдөр		
1	2 - 10	Төлөөлөгчдийн Танхим	Намын дотоод сонгууль зохион байгуулах төв ажлын хэсэг байгуулах, Дүрмийн 16.3 дахь заалтын 16.3.1.
	11-25	Аймаг, дүүрэг, нийслэлийн Танхим	Аймаг, дүүрэг, нийслэлийн танхимын санхүү, үйл ажиллагааны нэгдсэн тайланг хэлэлцэх. Дүрмийн 11.9.5.
	11-25	Сум, хорооны Танхим	Дотоод сонгуулийн сум, хорооны ажлын хэсэг байгуулах, Дүрмийн 10.4.2. Сум, хорооны санхүү, үйл ажиллагааны тайланг хэлэлцэж батлах. Дүрмийн 10.4.5.
	1-25	Үнэт зүйлийн зөвлөл	Өмнөх оны нийгэм, улс төр, эдийн засгийн байдлыг дүгнэх ээлжит хурал
	Сарын сүүлийн ажлын өдөр	Дотоод аудитын хороо	Намын үйл ажиллагаа, санхүүгийн байнгын хяналтын ээлжит дүн. Дүрмийн 24.1-24.3
2	24-ний өдрөөс өмнө	Төлөөлөгчдийн Танхим	Маргаан таслах комиссын гишүүдийн 30 хүртэлх хувийг дүрмийн 19.5-д заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд нөхөн сонгох. Дүрмийн 9.6.11.
	Сарын сүүлийн ажлын өдөр	Дотоод аудитын хороо	Намын үйл ажиллагаа, санхүүгийн байнгын хяналтын ээлжит дүн. Дүрмийн 24.1-24.3
3	8-18	Сум, хорооны салбарын	Дотоод сонгуулийн санал хураалт.



		бүх гишүүдийн хурал Сум, хорооны Танхим	Дүрмийн 10.2.1-10.2.2 Дүрмийн 10.4.3
	19-25	Аймаг, дүүрэг, нийслэлийн Танхим	Дотоод сонгуулийн санал хураалт. Дүрмийн 11.9.1.
	26-28	Төлөөлөгчдийн Танхим	Дотоод сонгуулийн санал хураалт. Дүрмийн 9.6.1-9.6.3.
	29-31	Намын Их Хурал	Дотоод сонгуулийн санал хураалт. Дүрмийн 9.2.2, 9.2.4. Намын Төлөөлөгчдийн танхим, Маргаан таслах комиссын тайланг хэлэлцэх.
	1-31	Маргаан Таслах Комисс	Дотоод сонгуулийн тухай маргааныг эхний ээлжинд авч хэлэлцэнэ.
<b>4</b>	1-25	Үнэт зүйлийн зөвлөл	Нэгдүгээр улиралын нийгэм, улс төр, эдийн байдлын талаар дүгнэх ээлжит хурал
	1-30	Маргаан таслах комисс	Дотоод сонгуулийн тухай маргааныг эхний ээлжинд авч хэлэлцэнэ.
	Сарын сүүлийн ажлын өдөр	Дотоод аудитын хороо	Намын үйл ажиллагаа, санхүүгийн байнгын хяналтын ээлжит дүн. Дүрмийн 24.1-24.3
<b>5</b>	1-25	Төлөөлөгчдийн Танхим	Дүрмийн 9.6.6-9.6.8 хэлэлцэх. Энэ хугацаа нь хуулийн өөрчлөлтөөс хамаарч өөр сард байж болно.
	Сарын сүүлийн ажлын өдөр	Дотоод аудитын хороо	Намын үйл ажиллагаа, санхүүгийн байнгын хяналтын ээлжит дүн. Дүрмийн 24.1-24.3
<b>6</b>	Сарын сүүлийн ажлын өдөр	Дотоод аудитын хороо	Намын үйл ажиллагаа, санхүүгийн байнгын хяналтын ээлжит дүн. Дүрмийн 24.1-24.3
<b>7</b>	1-31	Төлөөлөгчдийн Танхим	Дүрмийн 9.6.6-г хэлэлцэх. Энэ хугацаа нь хууль болон улс төрийн нөхцөл байдлас хамаарч өөр байж болно.
	Сарын сүүлийн ажлын өдөр	Дотоод аудитын хороо	Намын үйл ажиллагаа, санхүүгийн байнгын хяналтын ээлжит дүн. Дүрмийн 24.1-24.3
<b>8</b>	1-31	Үнэт зүйлийн зөвлөл	Хоёрдугаар улиралын нийгэм, улс төр, эдийн засгийн байдлыг дүгнэх ээлжит хурал
	Сарын сүүлийн ажлын өдөр	Дотоод аудитын хороо	Намын үйл ажиллагаа, санхүүгийн байнгын хяналтын ээлжит дүн. Дүрмийн 24.1-24.3
<b>9</b>	1-25	Сум, хорооны бүх гишүүдийн хурал	Дүрмийн 10.2.3-10.2.4-г хэлэлцэх. Энэ хугацаа нь хуулийн өөрчлөлтөөс хамаарч өөр байж болно.
	1-25	Аймаг, дүүрэг, нийслэлийн Танхим	Дүрмийн 11.9.2-11.9.3-г хэлэлцэх. Энэ хугацаа нь хуулийн өөрчлөлтөөс хамаарч өөр байж болно.
	Сарын сүүлийн	Дотоод аудитын хороо	Намын үйл ажиллагаа, санхүүгийн байнгын хяналтын ээлжит дүн.

	ажлын өдөр		Дүрмийн 24.1-24.3
10	Сарын сүүлийн ажлын өдөр	Дотоод аудитын хороо	Намын үйл ажиллагаа, санхүүгийн байнгын хяналтын ээлжит дүн. Дүрмийн 24.1-24.3
11	1-25	Үнэт зүйлийн зөвлөл	Гуравдугаар улиралын нийгэм, улс төр, эдийн засгийн байдлыг дүгнэх ээлжит хурал
	Сарын сүүлийн ажлын өдөр	Дотоод аудитын хороо	Намын үйл ажиллагаа, санхүүгийн байнгын хяналтын ээлжит дүн. Дүрмийн 24.1-24.3
12	1-10	Төлөөлөгчдийн Танхим	Намын төсөв баталж, тухайн жилд төлөх гишүүний татварын хэмжээг тогтоох, Ээлжит дотоод сонгуулийн товыг тогтоох.
	11-20	Аймаг, дүүрэг, нийслэлийн Танхим	Аймаг, дүүрэг, нийслэлийн салбарын төсвийг батлах, дүрмийн 11.9.5.
	21-30	Сум, хорооны Танхим	Сум, хорооны салбарын төсвийг батлах
	Сарын сүүлийн ажлын өдөр	Дотоод аудитын хороо	Намын үйл ажиллагаа, санхүүгийн байнгын хяналтын ээлжит дүн. Дүрмийн 24.1-24.3

5.4. Дотоод аудитын хурал нь дотоод сонгууль явагдах гуравдугаар сард хуралдахгүй боловч дараа сарын хурлаар гуравдугаар сард хэлэлцэх асуудлыг нөхөн хэлэлцэнэ.

### **Зургаа. Хурал, санал хураалт, сургалт, маргаан шийдүүлэх ажиллагааг цахимаар зохион байгуулах горим**

6.1. Хурал зарлах, хурал хуралдуулахыг шаардах эрх бүхий субъект хурлыг товлосон буюу шаардсан шийдвэрт гарын үсэг зурж, сургалт, уулзалт зохион байгуулах хүсэлтэй гишүүн уг үйл ажиллагааны хуваарийг товлож тус тус Намын Ерөнхий менежерт хүргүүлнэ. Шийдвэр, шаардлага, хүсэлтийн хувийг [genmanager@cup.mn](mailto:genmanager@cup.mn) ба [registrar@cup.mn](mailto:registrar@cup.mn) хаяг руу цахимаар илгээнэ.

6.2. Маргаан Таслах Комисст хандан маргаан үүсгэж байгаа гишүүн өргөдлөө [auditor1@cup.mn](mailto:auditor1@cup.mn) хаяг руу илгээнэ.

6.3. Хурал, уулзалт, сургалтаар хэлэлцэх асуудал болон санал хураах асуудлыг хүсэлтэд тодорхой заасан байна.

6.4. Энэ журмын 6.1-д заасан хүсэлтийг заасан и-мейл хаягаар хүлээн авснаас хойш Намын ерөнхий менежер, Бүртгэгч нар дараах үйл ажиллагааг явуулна:

6.4.1. Эрх бүхий субъектийн товлон зарласан хурал нь дотоод сонгуулийн үйл ажиллагаа агуулж байвал хурлыг үүсгэхдээ дотоод сонгуулийн товтой нийцүүлэх тухай хариу мэдэгдэх;

6.4.2. Хурал, уулзалт, сургалтын линкийг намын лицензтэйгээр ашиглаж буй цахим талбарт 72 цагийн дотор үүсгэж линкийг намын апп-аар гишүүдэд түгээх;

6.4.3. Хурлыг намын апп дээр нэр, огноо заан үүсгэж, тус хуралд санал таслах эрхтэй гишүүдийг системд идэвхижүүлэх.

6.4.4. Хурлын санал хураалтын саналын хуудсыг энэ журмын 6.4.3-т засан хурлын цэсэнд

оруулах.

6.4.5. Олон хурлыг зэрэг зохион байгуулах үед техник туслалцаа үзүүлэх зорилгоор хурлуудад санал таслах эрхгүй сайн дурын ажилтан хуваарилж ажиллуулах;

6.5. Хурал, уулзалт, сургалтын зарыг товлосон гишүүн болон эрх бүхий албан тушаалтан хурлын линк үүссэнээс хойш дараах үйл ажиллагааг явуулна.

6.5.1. Хуралд санал таслах эрхтэй оролцох гишүүдэд намын дүрмийн 25.5-д заасан тусгай зар хүргэх ажлыг зохион байгуулах, энэ ажилд намын тухайн шатны ажлын албанаас туслалцаа авах;

6.5.2. Намын апп-д үүсгэсэн хурлын цэсэнд санал таслах эрхтэй гишүүдийн бүртгэл, санал хураалтын саналын асуултууд бүрэн, зөв орсон эсэхэд хяналт тавих, алдаа гарсан бол засуулах;

6.5.3. Хурал эхлэхийн өмнө хуралд санал таслах эрхтэй, ажиглагчаар оролцож буй гишүүдийг тусад нь бүртгэх.

6.5.4. Хурал, сургалт, уулзалтыг удирдан эхлүүлэх. Хурлын явцад ажлын албанаас техникийн туслалцаа авах.

6.6. Маргаан таслах комиссын хурлын нийтлэг болон тусгай зар түгээх үүргийг Маргаан таслах комисс хариуцна.

6.7. ИОНН-ын бүх хурал, сонгууль нээлттэй байна.

6.8. Намын хурлыг намын дүрмийн 25.8-д заасан ирсэн ирцээр хуралдуулна.

Долоо. Бусад зүйл

7.1. Энэ журамд тусгаагүй бусад харилцааг зохицуулахдаа Иргэдийн Оролцооны Нэгдэл Намын дүрэм, түүнтэй холбогдох бусад журмыг үндэслэн зохицуулна.

7.2. Хэрэв энэ журам, бусад журмын заалтууд хэрэгжүүлэх явцад зөрчилдвөл намын дүрмийг баримтална.

7.3. Энэ журмыг 2022 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.